

## ЗОНХАВЫН “БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ” ДЭХ БОДГАЛИЙН БИ ҮГҮЙН ТАЛААРХИ ҮЗЭЛ САНАА

О. ЧИМЭГ  
МУИС, НШУС, Шашин судлалын тэнхим

### Түлхүүр үг:

Бодгалийн би үгүй, таван цогц, мөнхийн сүнс.

Шарын шашин хэмээгдэх гэлүгва чиглэлийн үндэслэгч богд лам Зонхава “Бодь мөрийн зэрэг” зохиолдоо их төрөлхтөний явдлыг хураасан зургаан барамидын сүүлчийн хоёр болох дияан, билгийн тухай үзэл санаагаа амарлин оршихуй хийгээд үлэмж үзэхүйн сургаалаар дэлгэрэнгүй номлосон байдаг. Үүнд үлэмж үзэхүйн сургаал нь бодгалийн би үгүй ба номын би үгүйн хоосон чанарыг ухаарч, үнэмлэхүй үнэнийг оноход зориулагддаг. Иймээс ч янагуухи хийгээд үнэмлэхүй үнэний мөн чанар, тийн ялгалыг нарийвчлан авч үзсэн байх ажээ.

Бодгалийн би үгүй ба номын би үгүйн хоосон чанарын үзэл санааны тухайд номын би-д шүтэж, бодгалийн би-д барих үзэл үүсэх хэдий ч би үгүйг нотлон буулгахад бодгалийн би үгүйд шүтэж, номын би үгүйн онол төрөх тул бодгалийг би үгүйг эхэнд нь номлосон байна.

### Бодгалийг танин барих

Буддын философид бодгаль хэмээн амьд амьтан, юуны өмнө хүнийг нэрлэдэг бөгөөд тэрээр мэдрэхүйн эрхтэн, ухамсар ба түүгээр дамжин илэрч байгаа гадаад юмс үзэгдлийн харилцан шүтэлцээний бэлгэ чанаруудыг илэрхийлсэн 75 дхармын бүрдэл болох 5 цогцын чуулган. / 3, 12 / Дүрс, сэрэхүй, хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, тийн мэдэхүй гэх эдгээр цогцыг бүдүүвч утгаар орчин үеийн сэтгэл судлалын ухааны дүр, сэрэхүй, хүртэхүй, төсөөлөхүй, ухамсар зэрэгтэй дүйцүүлэн ойлгож болох юм. Дээрх таван цогцод шүтэж, “янагуухи амьтан хэмээдэг” тухай “Бодь мөрийн зэрэгт” өгүүлдэг. Харин бодгаль хэмээх энэ таван цогцын чуулганд өөрөөсөө бүтсэн буюу ямар нэгэн байнгын хувирч өөрчлөгдөхгүй чанар байна уу, үгүй юу гэдэг асуудал тавигдахад тийм байнгын, хувирч өөрчлөгдөхгүй чанар үгүй хэмээн үзэж энэ асуудлыг бодгалийн би үгүйн тухай ойлголтоор илэрхийлдэг. Бодгалийн би-ийн тухай ойлголтыг мөнхийн сүнсний тухай европын философид тавигддаг асуудалтай холбон тайлбарласан явдал европын буддын судлаачдын ном зохиолд байдаг.

Оросын буддын судлаач М.Г.Брянскийн "Опровержение понятия личности" хэмээх судалгааны өгүүлэлд Васубандугийн Gan- zag dgag-ра bstan-ра /"Бодгалийг хорихыг үзүүлэхүй"/ зохиолыг орчуулсан оросын буддын судлаач Ф.И.Щербатской, Бельгийн дорно дахины судлагч В. Пуссен нар бодгалийн би үгүйд холбогдох нэр томъёог хэрхэн орчуулсныг хүснэгтээр харьцуулжээ / 2 /. Энэ хүснэгтээс үзэхэд Ф.И.Щербатской окү буюу би-г душа, постоянная душа, (реальная) душа, (эмпирическое) я, эго хэмээн орчуулжээ. Душа хэмээх ойлголт нь орос хэлэнд эртний шашнууд болон христос шашин дахь мөнх бус биеийг эзлэх боловч тэр биеийн задралаас үл хамаарах мөнх хувиршгүй, байнгын "субстанцийг" илэрхийлэх бөгөөд монгол хэлэнд үүнд хамгийн ойрхон ойлголт бол сүнсний тухай ойлголт юм. Би-г ийнхүү илэрхийлсэн нь би хэмээхийг мөнхийн сүнсний тухай ойлголттой ойртуулан авч үзсэн хэрэг юм. Энэ асуудлыг европын ялангуяа христос шашны философид нэлээд авч үздэг бөгөөд дүгнэлтүүд нь хэдийгээр өөр боловч буддын философи дахь бодгалийн би-ийн тухай асуудлыг европын философи дахь мөнхийн сүнсний тухай ойлголттой нэг хүрээний асуудал гэж үзэж болох байх гэж бодогдоно. Учир нь "Бодь мөрийн зэрэг"-ээс үзэхэд хэдийгээр бодгаль хэмээх нь бие, сэтгэлийн нийлбэр цогцыг илэрхийлсэн ойлголт боловч бодгалийн би-ийн тухай асуудал нь бодгаль дахь ямар нэгэн байнгын, хувиршгүй чанар байх эсэх тухай асуудал юм. Энэ асуудлыг авч үзээд богд Зонхава тийм байнгын, хувиршгүй чанар бодгальд үгүй хэмээн үзсэн байна.

"Бодь мөрийн зэрэг"-т "Бодгаль хэмээхүй нь тэнгэр тэргүүтэн зургаан зүйл бодгаль хийгээд эгэл хийгээд хутагтан бодгаль тэргүүтэн мөн. Төр ч цагаан, хар үйлийг хураагч хийгээд түүний үрийг амсагч хийгээд орчлонд орчигчин хийгээд нирвааны тул мөрийг бясалгагчин ба нирвааныг ологч болой" (1,179б) хэмээн тодорхойлжээ. Ийнхүү бодгаль гэдэгт тэнгэр, асур, хүн, адгуус, бэрд, там зэрэг зургаан зүйлийн хамаг амьтан багтан орох хэдий ч юуны өмнө дээрх бүх амьтны сэтгэлийн зовлонг өөртөө агуулдаг, түүнээс гэтэлгэх зорилго тавьдаг санаа бодлын хувьд харилцан адилгүй хүн юм.

Харин энэхүү бодгалийн би хэмээх нь өөрийн мөн чанар үгүй бөгөөд үүнийг би үгүйн ойлголтоор илэрхийлдэг. Өөрийн зохиолдоо богд Зонхава бодгалийн би үгүйн талаархи хэд хэдэн нотолгоог гарган тавьсан байна.

Буддын философид би гэж бусад юмс үзэгдэлтэй холбоогүй, ямар нэгэн шалтгаан нөхцлөөс хамааралгүй, өөрийн бэлгэ чанараар бүтсэн зүйлийг хэлнэ хэмээх болзлыг тавьдаг.

"Бодь мөрийн зэрэг"-тээ богд Зонхава Шантидевагийн "Бодьсадвагийн явдалд орохуй" зохиолын тайлбараас эш татан бодгальсын би хэмээн баримтлах нь шимнусын сэтгэл, тэр мэт баримтлах нь муу үзлийн эрхэд болсон, хуран үүдсэн энэхүү цогц нь хоосон бөгөөд дээд утгатаа бодгалийн би нь үгүй хэмээн үзүүлсэн байна.

Үүнтэй холбогдуулан Зонхава бодгальсын би хэмээх өөрөөсөө бүтсэн буюу хувирч өөрчлөгддөггүй ямар нэгэн чанар байдаг бол тэр нь бодгалийг бүрдүүлж байгаа таван цогцтой эсвэл нэг чанартай, эсвэл ангит чанартай байх ёстой, үүнээс "бусад дор бүтэх арга үгүй" гэж үзээд аль алийг нь няцааж бодгалийн би үгүйг нотлон харуулсан байдаг (1,1796-1826).

Бодгалийн би үгүйг няцаах үндсэн нотолгоо нь бодгаль хийгээд цогцос хоёр өөрөөсөө бүтсэн нэг чанартай, эсвэл ангид чанартай гэж үзвэл ямар гэм буюу логик зөрчил байхыг харуулахад оршиж байгаа бөгөөд зарим нотолгоо нь Нагаржуна, Шантидева зэрэг Энэтхэгийн алдартай сэтгэгчдээс уламжлалтай байх ажээ. Эдгээр нотолгоог утгачлан авч үзвэл:

**Бодгаль хийгээд цогцос өвөрчлөнгөөр бүтсэн нэгэн чанартай дор ямар гэм байхыг үзүүлэх**

Хэрэв бодгаль цогцос хоёр өөрөөсөө бүтсэн нэг чанартай юм бол гурван гэм байх ажээ.

Нэгдүгээр гэм. Тэр хоёр нэг чанартай, тэр нь өөрөөсөө бүтсэн юм бол ерөөс *ялгал үгүй* нэг болно.

Тэр тохиолдолд цогцсыг авч, гээн үйлдэгч эзэн нь үнэхээр бүтсэн байх болно. Гэтэл таван цогцсыг үнэхээр бүтсэн би гэж үзвэл түүнийг авч, гэж байдаг хэрнээ түүнтэй нэг чанартай би байна гэж үзэх нь утгагүй болно гэжээ.

Учир нь хүний сэрэхүй, хуран мэдэхүй зэрэг субъектив ертөнцийг бүрдүүлэгч бэлгэ чанарууд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Тэгвэл өөрийн бэлгэ чанараар бүтсэн би буюу хувьсан өөрчлөгдөхгүй ямар нэгэн чанар байх атлаа байнга хувьсан өөрчлөгдөж байгаа таван цогцтой нэг чанартай гэж үзвэл утгагүй болохыг энэ нотолгоогоор илэрхийлэн харуулсан байна.

Хоёрдугаар гэм. Хэрэв би, цогцос хоёр нэг чанартай, тэр нь өөрөөсөө бүтсэн юм бол *би олон болох гэм* байна. Хэрэв би цогц нугуудтай нэг юм

бол нэг бодгаль дор ч олон цогц байх учраас би ч олон болно. Харин би нэг байх ёстой бол цогц нугууд ч нэг л байх ёстой болно.

Гуравдугаар гэм. Хэрэв би, цогц хоёр нэг чанартай, тэр нь өөрөөсөө бүтсэн юм бол би төрөхүй, эвдрэхүй болох гэм байна гэж Нагаржунагийн "Үндэс билигт" заасан.

Учир нь цогц төрж, эвдрэхэд түүнтэй нэг чанартай би ч агшин бүр төрж эвдэрнэ гэсэн үг. Гэтэл бид бодгалийг өөрийн бэлгэ чанараар бүтсэн хэмээн ам авсан учраас бодгаль өөрийн мөн чанараар бүтсэн төрөхүй, эвдрэхүй гэж үзэх зөрчил үүснэ. Энэ тохиолдлын талаар Зонхав Шантидевагийн "Бодьсадвагийн явдалд орохуй" зохиолын тайлбар дахь гурван гэмийг эш үндэс болгожээ.

Бодгаль нь өөрийн мөн чанараар бүтсэн төрөхүй, эвдрэхүй бол дараах зөрчил байх болно:

1. Урьд хойд агшнууд барилдлагагүй болох гэм:

Бодгаль нь өөрийн мөн чанараар бүтсэн төрөхүй, эвдрэхүй бол өөрийн мөн чанараар бүтсэн би нь бусадтай хамааралгүй байна гэсэн нөхцлийн дагуу урьд, хойд агшнууд хоорондоо барилдлагагүй болно. Тийм бол би урьд нь ийм байгаад, одоо ийм болов гэхийн аргагүй, мөнхөд хэвээрээ өөрчлөлтгүй байх болно.

2. Үйл үйлдсэн шилэгдэхийн /сүйдэхийн/ гэм.

Би төрж эвдрээд байдаг бол үйл үйлдэгч хийгээд үрийг амсагч хоёул хоорондоо барилдлагагүй болно.

3. Эс үйлдсэн үйлс лүгээ учрахын гэм.

Хэрэв урьд, хойд агшнуудыг нэгтгэх би байгаа гэж үзвэл нэг хүний хийсэн үйлийн үрийг өөр хүн амсах болж байгаа хэрэг.

#### **Бодгаль хийгээд цогцос өөрөөсөө бүтсэн ангид чанартай дор ямар гэм байхыг үзүүлэх**

Би хийгээд цогцос хоёрыг өвөрчлөнгөөр бүтсэн ангид хэмээн үзвэл цогцоос бус цогцын бэлгэ чанар байх гэм гарна. Энэ гэмийн талаар Нагаржуна "Үндсэн билиг" зохиолдоо "цогц нугуудаас бус цогцын бэлгэ чанар үгүй болму" хэмээн номлосон байдаг тухай "Бодь мөрийн зэрэг"-т эш үндэс болгожээ /1, 182 б/.

Хэрэв бодгалийн би, цогц хоёр өөрөөсөө бүтсэн ангид чанартай бол "цогц хуран үүдсэндор үлих (илрэх) бэлгэ чанар нь төрж, эвдрэх, орших лугаа үл төгсөх болох буюу. Үлгэрлэвээс морь нь үхрээс бус утга дор бүтсэний тул үхрийн бэлгэ чанар лугаа эс төгссөнчлөн болой...", "хуран эс

үүдсэн мөний тул үлгэрлэвээс огторгуйн цэцэг ба гаслангаас нөхцсөнчлөн болой", "үлгэрлэвээс бие, сэтгэл ангит дор зорихчлон болой" (1,182б-183а) хэмээн таван цогцоос ангид буюу ямар ч сэрэхүй, мэдрэхүйгээс ангид би байна гэж үзвэл тэр нь ямар ч зовлон эдлэхгүй, огторгуй мэт бариад авах юм үгүй болох гэгийг дурьджээ.

Тийм учраас "цогцоос бус би үгүй буюу. Цогц бус түүнийг барих эс бүтсэний тул хэмээн номлов" гэжээ (1,183 а).

Бодгалийн би үгүйн дараа минийх өөрийн мөн чанараар үгүйг дараах байдлаар нотлон харуулсан байдаг.

### **Минийх өвөрчлөн чанар үгүйг нотлон буулгах**

Минийх өвөрчлөн чанар үгүйг нотлон буулгах хэсэгтээ богд Зонхав Нагаржунагийн "Үндэс билиг"-ээс эш татан "би буй бус бөгөөс минийх буй дор яаж болму", мөн түүнчлэн Шантидевагийн "Орохуй"-гаас эш татан: "алины тул үйлдэгч үгүй дор үйлс үгүй, тиймийн тул минийх нь би үгүй дор буй бус, тиймийн тул би хийгээд миний хоосныг үзсэнээр тэр егүүзэр тийн бөгөөд тонилох болму хэмээв" /1, 183 б/ гэж үйлдэгч үгүй бол үйлс ч байхгүй учир минийх хэмээн зорихыг хүүсэр эмийн хөвгүүнийг зорихтой адил хэмээн зүйрлэжээ.

Бодгалийн би-гийн тухай ойлголтыг өөрөөсөө бүтсэн, хувирч өөрчлөгдөхгүй би-гийн тухай асуудал болгон тавьж байгаа нь угтаа хувирч өөрчлөгдөхгүй, мөнхийн сүнсний тухай асуудал мөн болж байгаа мэт байна. Байнгын, хувирч өөрчлөгдөхгүй би-ийг ертөнцийг мэдрэн хүртэгч бие сэтгэлийн цогц болох бодгальтай нэг гэж үзэхийн аргагүй, нөгөө талаар тэрхүү би нь цогцоос ангид бол тэрхүү цогцод "би" хэмээн тэмүүлээд байх зүйлгүй болох учраас бодгалийн би-ийг үгүй хэмээн няцаажээ.

Бодгалийн би үгүй ба минийх би үгүйн талаарх үзэл санаа нь хамаг нисванисын ёзоор, "хамаг гэгий шүтээн" болох би-д барих мунхаг үзлийг дарахад зориулагдсан байх бөгөөд номын би үгүйн үзэл санаагаар нарийвчлан гүнзгийрч энэхүү үзэл санаа нь "биеэр илт болгох" хэмжээнд бясалгаж нирваны амгаланд хүрэхэд зориулагджээ.

**Summary**

Views on Pudgala's Non-Ego in the  
"Grades of the Path to Bodhi" by Tsonkapa

Dr. Chimeg O. (PhD.)

Lecturer of Buddhist Philosophy, National University of Mongolia.

The founder of Gelugpa, the Buddhist direction spread in Tibet and Mongolia, Tsonkapa in his main work "Grades on the Path to Bodhi" spares special attention to last two of six perfections, concentrative meditation and discriminating awareness. Contents of his teaching on awareness is dedicated to ideas of emptiness, Pudgala's and Dharmas' Non-Ego.

The author of the article considers views on Pudgala's Ego as very close to ideas of eternal soul, existence of which Tsonkapa as well as other Buddhists reject

**Ашигласан ном зохиол**

1. - Лувсандагва (Зонхава). Гурван төрөлхтний анхааран авах бодь мөрийн зэрэг оршвой. Бээжин бар (Төвд хэл дээр). Цаасны хэмжээ 49,5x9.5. Барын хэмжээ 27x6. Мөрийн тоо 5. Хуудасны тоо 223 /эшлэлийг энэ номоор заав/.

- Лувсандагва (Зонхава), Бага бодь мөрийн зэрэг оршив. Төвдийн Моллом равжамба хийгээд Монголын гүүш Наганзуна Жүдва аягаа тахимлиг нарын монгол орчуулгаас хийсэн гар бичмэл /эшлэлүүдэд энэ орчуулгыг голлон тулгуурлав/.

2. М.Г.Брянский. О европейских переводах трактата Васубанду "Опровержение понятия личности"- Исследования по истории и филологии Центральной Азии. Улан-Удэ., 1976

3. М.Гантуяа. Буддын философи дахь таван цогцын тухайд. Эрх чөлөө ба философи. №1. УБ., 1998

4. О. Чимэг. Бясалгал буюу танин мэдэхүйн цөм - Зонхавын "Бодь мөрийн зэрэг" дэх нийгмийн философийн үзэл санаа. Философийн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалсан диссертац II бүлэг. УБ., 2001